



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/562


Есөнбулаг

Авто замын трасс баталж,
хамгаалалтын бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Авто замын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт хатуу хучилттай авто зам барих ажлын трассын байршил хэмжээг нэгдүгээр хавсралтаар, хамгаалалтын бүсийн зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус тогтоосугай.
- 2.Авто замын трассын дагуу газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг шинэчилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.
- 3.Замын хамгаалалтын орчны бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн замын аюулгүй байдалд нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавьж, хамгаалалтын бүстэй холбоотой мэдээллээр олон нийтийг хангаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Untitled Map
Write a description for your map

Google Earth

2023 оны 12 дугаар сарын 15 өдрийн 15:30 цагаар захирамжийн хэвсрэлт

Бүсний төлөв
Замууд

Legend

